БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2020/39/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2020 он


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээнням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Должмаа
Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил Үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга

Аудитын гэрчилгээ ..... 3

Аудитын тайлан ..... 5

2.1. Оршил ..... 5

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 5

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 5

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 6

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 6

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 6

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 6

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 7

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 8

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 8

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 11

2.13. Шилэн дансны мэдээлэл ..... 13

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ..... 13

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 13

Менежментийн захидал ..... 15

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ..... 20

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ..... 20

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 21

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 22

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 23

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 24

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 26

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2020.02.24 № 1/270

танай ____________ -ны №____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН
ДАРГА Ц.ДАШЦЭРЭН ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

005020220

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

**Аудитын тайлан**

## 2.1. Оршил

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Ц.Дашцэрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 27–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлж, аудит хийлгэх тухай хүсэлтийг 2020 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 2/90 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх”-д оршино.

Баянхонгор аймгийн ЗДТГ нь 2019 оны үйл ажиллагааны чиглэлийг “Монгол улсын Засгийн газар, аймгийн 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого, аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Баянхонгор аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулж, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй, ил тод, хүртээмжтэй ажиллах” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 42 оноотой үнэлэгдсэн тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзэж аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн ЗДТГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous 4.10, цалингийн Payroll” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 35 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 22 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Их” гэж үнэлэн,

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

зардлын дүн тэрбум төгрөгөөс дээш дүнтэй тул материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1981225.3 мянган төгрөгөөс тооцон 19812.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар буюу 41982.9 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 22170.7 мянган төгрөгөөр өссөн нь төлөвлөлтийн шатанд Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2019 он 03 дугаар улирлын санхүүгийн тайланг татсантай холбоотой байна.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1804864.3 мянган төгрөгөөр буюу 38.1 хувиар өссөн байна. Энэ нь НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилтийн үлдэгдлийг орон нутгийн дансанд төвлөрүүлснээс авлага өссөн, архивын шинэ барилга улсын төсвийн хөрөнгөөр баригдаж, орлогод авснаас үндсэн хөрөнгө нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэ | Эцсийн үлдэгдэ | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| A | 1.00 | 2.00 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 170,914.78 | 311,680.87 | 140,766.10 |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | - | - |
| АВЛАГА | 5,881.19 | 139,736.49 | 133,855.30 |
| УРЬДЧИЛГАА | 1,099.85 | 1,693.83 | 593.97 |
| БАРАА МАТЕРИАЛ | 163,933.74 | 170,250.56 | 6,316.82 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 5,611,030.65 | 7,331,380.61 | 1,720,349.96 |
| ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ | (1,040,635.10) | (1,096,886.78) | (56,251.68) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,570,395.54 | 6,234,493.82 | 1,664,098.28 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 4,741,310.32 | 6,546,174.69 | 1,804,864.38 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР | 35,271.65 | 175,781.36 | 140,509.72 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,706,038.67 | 6,370,393.33 | 1,664,354.66 |
| Засгийн газрын хувь оролцоо | 4,706,038.67 | 6,370,393.33 | 1,664,354.66 |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,741,310.32 | 6,546,174.69 | 1,804,864.38 |

Тус байгууллага Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй оны эцэст 133855.3 мянган төгрөгийн авлага, 1804.8 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 6316.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 170250.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь байгууллагын үйл ажиллагаатай холбоотой аж ахуйн материал өмнөх оноос холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 1720439.9 мянган төгрөгөөр өсч оны эцэст 7331380.6 мянган төгрөг болсон нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1707595.8 мянган төгрөгийн архивын барилга баригдаж, орлогод авсантай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилтийн оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 129099.2 мянган төгрөгийг орон нутгийн дансанд төвлөрүүлснийг зардлаар бүртгэснийг аудитаар залруулснаас авлага, өглөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6370393.3 мянган төгрөг болж 1664354.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт 7 арга хэмжээний зардалд зориулан орон нутгийн төсвөөс 2222293.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 2222274.8 мянган төгрөг зарцуулж, төсвийг 18.9 мянган төгрөгөөр хэмнэсэн нь бараа үйлчилгээний бусад зардлын хэмнэлт байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын өөрийн орлогын төлөвлөгөөг архивын тасгийн орлогоор бүрдүүлдэг бөгөөд өөрийн орлогыг өмнөх оноос 15000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 55000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 68829.0 мянган төгрөг оруулж, давсан орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлж зарцуулжээ. Давсан орлогыг зарцуулахдаа хамт олны хурлаар хэлэлцэлгүй, зориулалт бусаар зарцуулсан байгаа менежментийн захидалд дурдсан болно.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:** Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 1690607.0 мянган төгрөг орсноос 1108687.7 мянган төгрөгийн орлого нь НҮБ-ийн Хүүхдийн сангаас олгосон санхүүжилт байгаа бөгөөд оны эцэст 129099.2 мянган төгрөгийг орон нутгийн дансанд төвлөрүүлсэн байна. Бусад 581919.2 мянган төгрөгийн 250000.0 мянган төгрөг нь Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас, 150557.7 мянган төгрөг нь “GIZ PAO” төслөөс, 27321.6 мянга төгрөг нь Үндэсний архивын газраас, 44525.0 мянган төгрөг нь “Топ ган дрилинг” ХХК-аас, 45000.0 мянган төгрөг нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас, 17831.5 мянган төгрөг нь Сангийн яам, Төрийн албаны зөвлөлөөс, 13000.0 мянган төгрөг нь Тогтвортой бичил уурхай төслөөс, 10461.1 мянган төгрөг нь Замын сангаас олгосон санхүүжилт ба 23222.3 мянган төгрөг нь Эйбл программын үнэ, түрээсийн орлого, даатгалын нөхөн төлбөр зэрэг бусад орлого байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 44 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 23 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 44 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 18 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 26 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал /сая.төг/

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 7 | 47.4 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 5 | 16.3 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 5 | 75.3 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 17 | 139.0 | |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитаар нийт 138958.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 16437.3 мянган төгрөгийн 5 алдаанд төлбөрийн акт тогтоож, 75338.3 мянган төгрөгийн 5 алдаанд албан шаардлага өгч, 47182.6 мянга төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгснийг менежментийн захидалд тусгав.

Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар НҮБ-ын Хүүхдийн сангаас нийт 1021166.3 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн ба оны эцэст тус орлогоос 129099.2 мянган төгрөгийг орон нутгийн дансанд төвлөрүүлсэн байхад зардлаар бүртгэсэн зөрчлийг арилгаж, санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгаж залруулга хийлээ.

**2.11.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.11.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган шалгахад тавилга хэрэгсэл 1299.0 мянга, аж ахуйн материалын үлдэгдэл 284.0 мянган төгрөгөөр зөрсөн ба энэ нь архивын тасагт ашиглагдаж байгаа хөрөнгө тусдаа нярвын бүртгэлтэй байгаатай холбоотой байна.

Жилийн эцсийн тооллогын комиссын бүрэлдэхүүнд байгууллагын тооцооны нягтлан бодогч, нярвыг оролцуулсан нь хөрөнгөд тавих хяналтыг сулруулах эрсдэлтэй тул цаашид зогсоох шаардлагатай байна.

Тус тооллогын дүнг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцсэн хурлын протоколтой танилцахад аймгийн Засаг даргын зөвлөхөөр ажиллаж байгаад 2018 онд ажлаас чөлөөлөгдсөн Ц.Энхтөрийн албан хэрэгцээнд ашиглагдаж байсан Dell i5 маркыг 1100.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 1200.0 мянган төгрөгийн air2 IPAD зэрэг хөрөнгийг байгууллагатай тооцоо хийж өгөөгүйгээс тооллогоор дутагдсан байна.

Дээрх зөрчлүүд нь Үнэн зөв байдал, Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 12 дугаар зүйлийн 12.2.4 дэх Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн.

2.11.1.2 Зардлын данстай холбоотой асуудал

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг тулган шалгахад 23 ажилтанд сагсан бөмбөгийн тамирын хослолыг 120.0 мянга, гар бөмбөгийн тамирын хослолыг 70.0 мянган төгрөгөөр хийлгэж, төсвөөс 4807.0 мянган төгрөгийн олгож, зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Мөн төсвийн хөрөнгөөс согтууруулах ундаа худалдан авахад 1208.0 мянга, бусад зориулалт бус зардалд 893,0 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.3 Балансын данстай холбоотой асуудал

Оны эхэнд 5881.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд авлага нэмэгдэж 10637.2 мянган төгрөгийн авлагатай болсон нь төрийн сангаар хийгдсэн 2019.12.25-ны өдөр "Арвин хонгор" ХХК-д шилжүүлсэн 4777.4 мянган төгрөгийн гүйлгээг давхардуулж татсан, Цэргийн штабын 746.8 мянган төгрөгийн гүйлгээг андуурч аймгийн ЗДТГ-ын данснаас гаргасантай холбоотой байна.

Оны эхний авлагыг судалж үзэхэд 5881.1 мянган төгрөгийн авлагаас тайлант онд 835.7 мянган төгрөгийн авлага барагдаж, 5045.4 мянган төгрөгийн авлага барагдаагүй үлдэгдлээр байна.

Байгууллагын ажиллагсдад олгосон цалингийн урьдчилгааг тухай бүр хааж, тооцоог дуусгадаггүйгээс 2018 оны эцэст 1099.8 мянга, 2019 оны эцэст 1693.8 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг барагдуулаагүй, авлагын үлдэгдлээр байна.

2019 онд байгууллагын үндсэн дансанд төсөвт байгууллагуудаас Эйбл программын төлбөрийн төлбөрт 3420.0 мянган төгрөг орсон байхад "Эйбл софт" ХХК-д 1050.0 мянган төгрөг илүү буюу 4470.0 мянган төгрөг шилжүүлсэн байхад авлагаар бүртгээгүй байна.

Хувь хүнээс худалдан авсан бараа материалын үнээс суутган тооцсон 44.0 мянга, ажлын хөлснөөс суутгасан 220.0 мянган төгрөгийг суутган тооцсон атлаа төсөвт төвлөрүүлээгүй, архивын тасгийн ажиллагсдад олгосон шагналаас 80.0 мянган төгрөгийн татвар суутган тооцоогүй байна.

Байгууллагын жолооч Баатарбилэгт дугуйны үнийг олгохдоо анхан шатны баримтаас 20.0 мянган төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Иж бүрэн байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.4 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд архивын барилга шинээр баригдаж ашиглалтад орсон бөгөөд архивын тасагт хандив тусламжаар бусад байгууллага, иргэдээс ирсэн хөрөнгийг орлогод авсныг шалгахад Acer брэндийн проектор самбар, Samsung-2070, Canon-6030 маркын хэвлэгч, хөлтэй самбар зэрэг нийт 4 хөрөнгийг үнийн дүн тодорхой бус шалтгаанаар орлогод аваагүй байна.

Энэ нь Оршин байх, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд ... бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.5 Балансын данстай холбоотой асуудал

Аймгийн Онцгой байдлын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн 2017.12.04-ний өдрийн 8/03 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар аймгийн Онцгой байдлын газарт албан тушаалын байр худалдан авах зардалд 52000.0 мянган төгрөг батлагдаж, "Би эйч энд ди" ХХК-д 51147.0 мянган төгрөг шилжүүлж, 2 өрөө байр худалдан авч хөрөнгөд бүртгээгүй зөрчил гарсан тул орон нутгийн өмчийн хөрөнгөөр авсан тус орон сууцыг аймгийн ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэх шаардлагатай байна.Тус зөрчил нь аймгийн ЗДТГ-ын санхүүгийн тайлагналтай холбоогүй тул зөрчлийн дүнгээс хасч тооцсон болно.

Энэ нь Оршин байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд ... бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

2.11.1.6 Зардлын данстай холбоотой асуудал

Мөнгөн хөрөнгийн журналыг анхан шатны баримттай тулгахад 2019 оны 04 дүгээр сард архивын тасгийн 5 ажилтан хөдөө сумдад 5 хоног ажилласан байхад 1 хоногийн томилолтын зардалд 132.5 мянга, мэргэжилтэн Т.Саранчимэгийн Увс аймаг ажилласан томилолтыг Улаанбаатар хотод ажилласан томилолтоор бодож 76.0 мянган төгрөг илүү олгосон, мэргэжилтэн М.Дүгэрмаа, гэрээт ажилтан Ш.Эрдэнэзул нарт 2019 оны 08 дугаар сард Улаанбаатарт ажилласан томилолтыг 3 хоногоор олгохоор байхад 1 хоногийн зардалд 138.0 мянган төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Үнэн зөв батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай Сангийн сайдын 2018 оны 301 тоот тушаалын 1, 2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.7 Балансын данстай холбоотой асуудал

Бичиг хэргийн материал дансанд бүртгэлтэй 100.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бараа материалд аудитаар биет тооллого хийхэд нэг бүрийн үнэ нь 2500 төгрөгийн үнийн дүн бүхий нийт 1000.0 сая төгрөгийн 400 ширхэг хавтас, 4500 төгрөгийн үнэ бүхий 210 боодол нийт 945.0 мянган төгрөгийн нүхтэй уут байхгүй байна. Энэ нь эдгээрийг байгууллагын ажилтнуудад тавьж олгосон атлаа зарлагадаагүйтэй холбоотой байна.

Ажиллагсдын эд хөрөнгийг тооллогод хамрагдсан хөрөнгөтэй тулган шалгахад тоо хэмжээгээр таарч байгаа боловч үнийн дүн зөрүүтэй байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Мөнгөн хөрөнгийн журналыг анхан шатны баримттай тулган шалгахад "Монголын цахилгаан холбоо" ТӨХК-аас 90.9 мянган төгрөгийн утасны аппарат худалдан авсан байхад шууд зардлаар тайлагнаж, орлогод бүртгээгүй байна.

Энэ нь Хэмжилт, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

2.11.1.8 Орлогын данстай холбоотой асуудал

Нэмэлт санхүүжилтийн дансны орлогыг тулгахад 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр иргэн Н.Энхсайхан “Star” ресторны улсын тэмдэгтийн хураамжийн 600.0 мянган төгрөгийн орлогыг тушаахдаа данс андуурч аймгийн ЗДТГ-ын дансанд тушаасныг санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэхээр байхад орлогоор бүртгэсэн байна.

Энэ нь Оршин байх, Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд ... бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.9 Зардлын данстай холбоотой асуудал

Үндсэн дансны харилцах дансаар нийт 1121, нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар 340, кассын гүйлгээгээр 205 гүйлгээ, нийт 1666 гүйлгээгээр 3914149.1 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн ба анхан шатны баримтын хангалтгүй, харилцах дансаар гарсан 12876.5 мянга, кассаар гарсан 5395.9 мянга, нийт 18272.4 мянган төгрөгийн гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Тохиолдсон байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

2.11.1.10 Зардлын данстай холбоотой асуудал

Байгууллагын даргын тушаалаар 2019 онд ажилд орсон хүмүүсийн ажилласан өдрийг олгосон цалинтай тулган шалгахад Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн Б.Чулуунчимэгт 4 өдрийн 100.9 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна.

Тайлант онд ажиллагсдаас 105707.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгасан байхад 106055.9 мянган төгрөг төлж, төсвөөс 348.7 мянган төгрөг илүү төлсөн нь О.Эрдэнэ-Оюун, Н.Ганбаатар нарын цалинг бодохдоо цалингийн программд дээрх 2

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

ажилтны даатгуулагчийн кодыг өөрчлөөгүйгээс цалингаас нийгмийн даатгалын шимтгэл дутуу суутгасантай холбоотой байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дэх заалт, Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө” гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2019 онд Ламын гэгээн Лувсандданзанжанцангийн ой тэмдэглэсэн, УИХ-ын дарга аймаг, сумдад ирж ажилласантай холбоотой урсгал зардал их гарсан ба аудитын хугацаа богино байсан тул нарийвчилсан горим сорил хийгдээгүй болно.

Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар НҮБ-ийн Хүүхдийн сангаас нийт 1021166.3 мянган төгрөгийн санхүүжилт орж, батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, үлдэгдлийг орон нутгийн дансанд төвлөрүүлсэн байна. Аудитын хугацаа богино, аймгийн ЗДТГ-ын гүйлгээний тоо, хэмжээ их байснаас нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг шалгах боломжгүй байсан тул НҮБ-ийн Хүүхдийн сангийн төлөөлөгчөөр тус сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын жагсаалтыг гаргуулан авч, ажлын баримтад авсан бөгөөд үүнийг цаашид шалгах шаардлагатай байна.

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн ЗДТГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудаст оруулсан байдлыг шалгахад дараах байдалтай байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 7 | 2 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 2 | 2 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 31 | 5 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 57 | 39 | |
| | Нийт | 27 | 151 | 101 | 48 | 2 |

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Баянхонгор аймгийн ЗДТГ нь 2018 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлээгүйн улмаас аудит хийгдээгүй тул зөвлөмж өгөөгүй байна.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг үзүүлэв. Үүнд:

3.1 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөд 228469.5 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 228467.4 мянган төгрөг зарцуулж, 2.1 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.2.1.2 дахь заалтыг зөрчиж нөөц хөрөнгөөс тайлант онд аймгийн Тагнуулын хэлтэст 3000.0 мянган төгрөгийн буйдан, шкаф, өлгүүр, ширээ зэрэг хөрөнгийг авч өгсөн байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах захирамжийг тулгахад захирамжийг гаргахдаа хууль эрх зүйн гол үндэслэл болох дээрх журмын заалтыг тавиагүй захирамжийг гаргасан байна.

